



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/36

Хатан суудал

Шар усны үерээс урьдчилан сэргийлэх
чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/188 дугаар захирамж зэргийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цаг агаарын дулааралтай холбогдуулан цас ихтэй уулархаг газар, гуу, жалга, гол, мөрөн, нуурын цас, мөс эрчимтэй хайлах, мөсний нягт багасаж шар усны үер буух аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хүртэл 30 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Цаг агаарын мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан гаргаж, иргэдэд шуурхай хүргэх, багц мессежээр олон давтамжтайгаар дамжуулах, цасан бүрхүүл болон гол, нууруудын мөсний зузаанд хэмжилт хийж, болзошгүй эрсдэлийн судалгаа гарган холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Цаг уурын ажилтан (Ц.Цэвэлмаа)-д,

3. Дээрх өдрүүдэд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зам тээврийн хөдөлгөөнд хяналт тавьж, аюулгүй байдлыг хангуулж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Г.Эрдэнэбилэг)-д,

4. Интернет орчинд иргэдийг гол, мөрөн, нуурын мөсөн дээгүүр зорчихгүй байх талаар анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээг тогтмол хүргэж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат)-д тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642101385